

2023 оны 06 сарын 30-ны
 өдрийн 34/2 тоот албан бичгийн хавсралт



**ӨНДӨРХААН ХК-ИЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ
 ТАЙЛАН**

2023.06.28

Улаанбаатар хот

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээний асуулга бүхий дараах байдалтай
 тайлан байна.

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	10		83.3%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10		100.0%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	4		66.7%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	5		83.3%
5	Эрсдэлийн удирдлага	8	7		87.5%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	4		66.7%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	6		75.0%
8	Компанийн соёл	6	6		100.0%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	8		80.0%
	Нэгдсэн дун	72	60		83.3%



Компанийн засаглалын үнэлгээний асуулга

Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана..

НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	<i>1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</i>	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулдаг.		2	100%
2	<i>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам,</i>	ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны журмаар зохицуулдаг.		2	100%

“ӨНДӨРХААН” ХК

	залгамж халааны бодлогын баримттай байна.				
3	1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туриллага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.	Үйл ажиллагааны тайланд тусгаж, МХБ-ийн цахим хуудсанд байршуулсан.	2023 оны жилийн үйл ажиллагааны тайлангаас эхлэн мэдээллийг бүрэн тусгана.	1	50%
4	1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн баталж, хүйсийн тэнцвэрт байдлыг тусгасан.		2	100%
5	1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	ТУЗ-ийн шинэ гишүүнийг шаардлагатай мэдээллээр хангадаг. Чиглүүлэх болон тогтмол сургалт, хөгжлийн хөтөлбөрт хамруулахаар шинэчилсэн үйл ажиллагааны журамд тусгасан.	Чиглүүлэх болон тогтмол сургалт, хөгжлийн хөтөлбөрийг цаашид боловсруулна.	1	50%
6	1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулдаг.		2	100%
ДҮН				10	
ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ					
7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	Компанийн тухай хуулийн 75.4-т заасны дагуу сонгосон.		2	100%
8	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл	ТУЗ-ийн аудитын хорооны журмаар		2	100%

АЙГ

ИДӨ

231
ИГЛ

	ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	зохицуулдаг. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байдаг. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага хорооны хүсэлтээр оролцдог.			
9	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	ТУЗ-ийн цалин урамшууллын хорооны журмаар зохицуулдаг. Тус хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байдаг. Цалин урамшууллын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага хорооны хүсэлтээр оролцдог.		2	100%
10	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байхаар ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны журамд тусгагдсан.		2	100%
11	2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	Байнгын болон түр хороо байгуулах талаар ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусгагдсан.		2	100%
ДҮН				10	
ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана					
12	3.1. ТУЗ нь компанийн	Мэдээллийн ил тод		2	100%

“ӨНДӨРХААН” ХК

	<i>мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	байдлын журмыг баталсан.			
13	<i>3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.</i>		Компани нь одоогийн байдлаар өөрийн цахим хуудасгүй байгаа ба 2023 оны хоёрдугаар хагаст өөрийн цахим хуудсыг үүсгэж, уг мэдээллийг олон нийтэд хүргэнэ.	1	50%
14	<i>3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.</i>		Санхүүгийн бус тайланг компанийн жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж цаашид тайлагнана.	1	50%
ДҮН				4	
ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО					
ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана					
15	<i>4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	ТУЗ-ийн аудитын хорооны журмаар зохицуулдаг.		2	100%
16	<i>4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.</i>	ТУЗ-ийн аудитын хорооны журмаар зохицуулдаг.		2	100%

17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	ТУЗ-ийн аудитын хорооны журмаар зохицуулдаг.	Компани нь одоогийн байдлаар өөрийн цахим хуудасгүй байгаа ба 2023 оны хоёрдугаар хагаст өөрийн цахим хуудсыг үүсгэж, уг мэдээллийг олон нийтэд хүргэнэ.	1	50%
ДҮН				5	
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА					
ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина					
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Эрсдэлийн удирдлагын журмыг баталсан.		2	100%
19	5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	Эрсдэлийн удирдлагын чиг үүргийг аудитын хороо хариуцдаг. Аудитын хорооны дарга, гишүүдийн олонх нь хараат бус гишүүд байдаг. Аудитын хорооны бүтэц, хурлын давтамжийн талаар тайлагнадаг.		2	100%
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.		Олон нийтэд цаашид мэдээлж, үйл ажиллагааны тайланд цаашид тусгана.	1	50%

“ӨНДӨРХААН” ХК

21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Комплайнсын хяналтын заавар, бүтцийг боловсруулж, баталсан.		2	100%
ДҮН				7	
ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна					
22	6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцээж батална.		Олон нийтэд цаашид мэдээлж, үйл ажиллагааны тайланд цаашид тусгана.	1	50%
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.	Цалин, урамшууллын бодлогын баримтыг боловсруулж баталсан.		2	100%
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллын шалгуурыг ТУЗ-тэй байгуулсан гэрээний дагуу тодорхойлдог.	Олон нийтэд цаашид мэдээлж, үйл ажиллагааны тайланд цаашид тусгана.	1	50%
ДҮН				4	
ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ					
25	7.1. Компани нь ТУЗ-оос баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлдэг.	Мэдээллийн ил тод байдлын журамд оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар тусгаж шинэчлэн баталсан.		2	100%
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны		Олон нийтэд цаашид мэдээлж,	1	50%

	<i>тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.</i>		үйл ажиллагааны тайланд цаашид тусгана .		
27	<i>7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.</i>		Компани нь одоогийн байдлаар өөрийн цахим хуудасгүй байгаа ба 2023 оны хоёрдугаар хагаст өөрийн цахим хуудсыг үүсгэж, үр дүнтэйгээр ажиллуулна.	1	50%
28	<i>7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.</i>	Хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулдаг.		2	100%
ДҮН				6	
НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ					
ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно					
29	<i>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	ТУЗ-ийн ёс зүйн кодексоор зохицуулдаг.		2	100%
30	<i>8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх "шүгэл үлээгчийн" тогтолцоотой байна.</i>	Комплаенсын хяналтын зааварт шүгэл үлээх ажиллагааны тухай оруулсан.		2	100%
31	<i>8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих,</i>	ТУЗ-ийн ёс зүйн кодекс, Ашиг сонирхолын зөрчлийн журмаар зохицуулдаг.		2	100%

“ӨНДӨРХААН” ХК

	/дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.				
ДҮН				6	
ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ					
Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					
32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	МХБ-ийн цахим хуудсаар дамжуулан уг мэдээллүүдийг хүргэдэг.	МХБ-ийн цахим хуудсаар дамжуулан уг мэдээллүүдийг хүргэдэг.	1	50%
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.			1	50%
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	Хувьцаа эзэмшигчид хууль ёсны эрхээ эдлэх нөхцөл, боломжоор хангадаг.	Хувьцаа эзэмшигчид хууль ёсны эрхээ эдлэх нөхцөл, боломжоор хангадаг.	2	100%
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Компанийн тухай хууль, холбогдох журам компанийн дүрэмд заасны дагуу эдгээр асуудлаар санал өгөх эрхээ хэрэгжүүлэх нөхцөлөөр хангагдсан.	Компанийн тухай хууль, холбогдох журам компанийн дүрэмд заасны дагуу эдгээр асуудлаар санал өгөх эрхээ хэрэгжүүлэх нөхцөлөөр хангагдсан.	2	100%
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	ТУЗ-ийн үйл ажиллагааны шинэчилсэн журамд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай боловсруулж, батлуулсан.	ТУЗ-ийн үйл ажиллагааны шинэчилсэн журамд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай боловсруулж, батлуулсан.	2	100%
ДҮН				8	
НЭГДСЭН ДҮН				60	83.3%